

замаар хэрхэн шийдвэрлэснээс хамаардаг болохыг дээрхи жишээ тод харуулж байна гэж дүгнэж байна.

П.Ууганбаяр-Дууль сахиулахын удирдлагын акаде.мийн
8062-р дамжааны суралцагч, магистр, хошууч

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООТОЙ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хураангуй. Энэхүү илтгэлээр Олон нийтэд түшиглэсэн гамшигийн эрсдэлийн менежментийн үе шатуудыг тодорхой болгож, цаашид удирдлага зохион байгуулалтын зарим арга замыг гаргаж ирэх талаар зорьсон болно.

Түлхүүр үг. Олон нийт, Удирдлага, Зохион байгуулалт.

Дэлхийн олон оронд тухайн улс үндэснийхээ онцлогийг тусган амжилттай хөгжиж буй олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийг бууруулах үзэл санаа манай улсад “Монгол Улсад гамшгийн аюулыг бууруулах менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь” төсөл ¹ -ийн үйл ажиллагааны хүрээнд 2000 оны эхээр анх нэвтэрсэн. Энэ хүрээнд хийгдсэн үндсэн үйл ажиллагаа нь орон нутгийн иргэдийн сайн дурын үүсгэл санаачлагад тулгуурлан байгуулагдсан бүлгүүдийг гамшгаас хамгаалах сургалтанд хамруулан чадавхжуулах, эрсдэлийг бууруулах бичил үйл ажиллагааг санхүүжүүлэхэд чиглэгдсэн* ² байна. Ийнхүү олон нийтэд тулгуурлаж гамшгийн эрсдэлийг бууруулах үзэл санаа манай улсад олон улсын байгууллагын дэмжлэг тусалцаатайгаар нэвтрүүлж эхэлсэн хэдий ч тухайн үед олон нийтийн оролцоог хангах, идэвх санаачилгыг нь дэмжих төрийн бодлого, эрх зүй, төсөв, санхүүгийн зохицуулалт хангалтгүй байснаас үүдээд төдийлэн үр дүнд хүрээгүй байсаар 2015 оныг хүргэсэн.

Монгол Улсын Засгийн газар 2015 онд “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотойбууруулах үндэсний хөтөлбөр”-ийг 2015-2025 онд хэрэгжүүлэхээр баталсан нь энэ үзэл санааг бодитой ажил хэрэг болгох суурь нөхцлийг бүрдүүлсэн гэж үзэж болно. Энэ үндэсний хөтөлбөрийн зорилго нь гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, сургалт, сурталчилгаа, үйл ажиллагаанд иргэдийг оролцуулан, тэдний мэдлэг, чадварыг дээшлүүлэх, аюулгүй амьдрах ухамсарт соёл болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхийг бэхжүүлэх замаар гамшгийн эрсдэлийг бууруулахад оршино³. Гамшгийн эрсдэлийг олон

¹Уг төсөл нь Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран Люксембургийн Засгийн газрын санхүүжилтээр 2002-2011 онуудад 3 үе шаттайгаар хэрэгжсэн юм.

² П.Байгальмаа., “Нутгийн иргэдэд түшиглэсэн гамшгийн менежментийг хөгжүүлэх шаардлага, ач холбогдол” илтгэл, 2011

³Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотойбууруулах үндэсний хөтөлбөрийн 2.1 дэх заалт

нийтийн оролцоотойбууруулах үндэсний хөтөлбөр”-ийг 2015-2025 онд хэрэгжүүлснээр энэ үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, тэдний идэвх санаачилгыг нь дэмжих төрийн бодлого, эрх зүйн орчин бүрдэж, төсөв, санхүүгийн зохицуулалт сайжирснаар манай улсадолон нийтийн оролцоонд тулгуурласан гамшгийн менежментийн тогтолцоо төлөвшиж, төрийн ачаалал багасна хэмээн үзсэн.

Энэхүү хөтөлбөрийн үндсэн хэрэгжүүлэгч байгууллага нь онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бөгөөд хамтран хэрэгжүүлэгч байгууллага нь бүх шатны төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага. төрийн бус байгууллага, хуулийн этгээд, гамшгаас хамгаалах албад. мэргэжлийн ангиуд. гамшгаас хамгаалах сайн дурынхан, хоршоо, нөхөрлөл, малчдын бүлэг, иргэд юм.

‘Тамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2016-2025 оны төлөвлөгөөны 2017 оны биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд биелэлт хангалтгүй байгаа үр дүн гарсан байна. Тухайлбал, 2017 ондэнэхүү хөтөлбөрийн 6 зорилтын хүрээнд 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөний биелэлт нь дөнгөж 44.1% хувьтай байна’.

Хүснэгт. Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөны 2017 оны биелэлт

Үндэсний хөтөлбөрийн зорилт		Биелэлт
Зорилт 1.	олон нийтийн оролцоонд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах эрх зүйн орчин, тогтолцоог бүрдүүлэх;	47,5%
Зорилт 2.	гамшгийн эрсдэлийг бууруулах олон нийтийн сургалт, сурталчилгааг бүх түвшинд шат дараалан зохион байгуулах;	44,28%
Зорилт 3.	олон нийтийн оролцоонд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх.	40%
Зорилт 4.	уур амьсгал, ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг шуурхай мэдээлэх тогтолцоог бэхжүүлэх;	40%
Зорилт 5.	уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийтийн оролцоо, идэвх, санаачилгыг дэмжих;	50%
Зорилт 6.	уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох	43%

	чадавхийг бэхжүүлэх.	
Хөтөлбөрийн зорилтын биелэлтийн дундаж		44.1%

Оролцоо нь холбогдогч талуудын идэвхи санаачилга, хүсэл эрмэлзлэлээс хамаарна. Оролцоо гэдэг дан ганц засгийн газар, төрийн байгууллагаас явуулдаг үйл явц биш, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд болон бусад холбогдогч талуудын санаачилга ихээхэн чухал байдаг.

Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийсэн тайлангаас үзэхэд байгууллага хоорондын буюу оролцогч талуудын хамтын ажиллагаа ихээхэн дутагдсанаас тус хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй болоход нөлөөлсөн гэж дүгнэсэн байна.

Одоогоор манай улсад гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үйл ажиллагаа ихэвчлэн олон улсын байгууллагын санхүүжилттэй төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байна.

Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийг батлагдсанаас хойш гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангахад чиглэсэн арга хэмжээнүүд эрчимжсэн байна. Тухайлбал одоогоор ОБЕГ-т нийт 9 төсөл хэрэгжиж байгаагийн 8 нь олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийг бууруулах, тэдний чадавхыг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжиж байна. Эдгээр төслүүдэд шинжилгээ хийж үзэхэд гамшигт өртөмтгий хөдөө орон нутгийн малчид болон хот суурин газрын иргэдийн гамшгийг даван туулах чадавхыг бэхжүүлэх, олон нийтийг гамшгийн эрсдэлээ бууруулахад нь дэмжлэг үзүүлэх цаашлаад гамшгийн үед ажиллах сайн дурын баг, гал түймэртэй тэмцэх олон нийтийн багуудыг байгуулах, чадавхжуулах чиглэлд арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна (Хүснэгт ...).

Хүснэгт ... Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах чиглэлд хэрэгжиж буй төслийн тойм

	Төслийн нэр, хамрах хүрээ	Хугацаа, хандивлагч	Хэрэгжүүлж буй гол арга хэмжээ
1	Төслийн нэр: Улаанбаатар хотын гамшгийн бэлэн байдлыг хангах, гамшигтай тэмцэх чадавхыг сайжруулах төсөл Хэрэгжүүлэгч: Монголын улаан загалмайн нийгэмлэг Төсөл хэрэгжсэн байршил:	Хугацаа: 2016-04 сараас- 2017-10 сар Хандивлагчид Европын холбоо Финландын Улаан загалмайн	...Улаан загалмайн хороодын хариу арга хэмжээ авах ур чадвар, чадавхыг бэхжүүлэх... ...Өсөн нэмэгдэж буй хотын орчны гамшгийн аюулын талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх

	Улаанбаатар хотын төвийн бдүүрэг	нийгэмлэг	
2	Төслийн нэр: Гамшигт тэсвэртэй Улаанбаатар төсөл Хэрэгжүүлэгч: Дэлхийн Зөн ОУБ, Хүмүүнлэгийн онцгой байдлын хэлтэс Төсөл хэрэгжсэн байршил: Баянзүрх, Багануур, Налайх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүргүүдийн нийт 7 хороо	Хугацаа: 2016 оны 10 сарын 03 аас 2018 оны 10 сарын 03 /2 жил/ Хандивлагч АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн Гадаад улс орнуудын гамшигт тусламж үзүүлэх газар	-Нийслэлийн түвшний төрийн байгууллагуудын гамшгийн менежментийг сайжруулах -Олон нийтэд чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулж, Улаанбаатар хотынболон гамшигт өртөмтгий орон нутгийн гамшгийн эрсдэлийг даван туулах чадавхыг нэмэгдүүлэх
3	Төслийн нэр: Гамшгийн Эрсдэлийг бууруулахад уламжлалт болоншинжлэх ухааны аргыг ашиглах төсөл Хэрэгжүүлэгч: Мерси Кор ОУБ Төсөл хэрэгжсэн байршил: 16 аймгийн 171 суманд: Ховд, Увс, Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай, Хөвсгөл, Өвөрхангай, Архангай, Баянхонгор, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Сүхбаатар, Дорноговь, Хэнтий, Булган	Хугацаа: 2014-2017 оны 1 сар 2018 оны 6 дугаар сар Хандивлагчид АНУ-ын ОУХА-ын харьяа Гамшигт нэрвэгдсэн гадаад орнуудад тусламж үзүүлэх газар	Шаардагдах цаг агаарын мэдээллийг түгээж орон нутагт гамшгийн төлөвлөлт болон эрсдэлийг бууруулах чадавхыг сайжруулснаар малчид болон хөдөөгийн эдийн засагт тохиох зудын эрсдэлийг бууруулах
4	Төслийн нэр:Зуд болон ой, хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төсөл Хэрэгжүүлэгч: Азийн Хөгжлийн Банк	Хугацаа: 2017 оны 12 дугаар сар - 2020 оны 4 дүгээр сар Хандивлагчид Ядуурлыг бууруулах	Олон нийтэдтулгуурласангамшгийн эрсдэлийн удирдлага (ОНТГЭУ)-ын төлөвлөгөөг боловсруулах, аргачлалыг туршин нэвтрүүлэх замаар гамшгийн эрсдэлээс

	Төсөл хэрэгжсэн байршил:17 аймаг	Японы Сан	сэргийлэх чадавхыг орон нутгийн түвшинд бэхжүүлэх
5	Төслийн нэр:“Хот суурин газрын гамшгийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх” төсөл Хэрэгжүүлэгч: Төсөл хэрэгжсэн байршил: УБ хотын төвийн 6 дүүргийн нийт 97 сургууль, 18 ААНБ, Улаан загалмайн 6 дунд шатны хороо	Хугацаа: 18 сар /2016-2017/ Хандивлагч: Европын комисс, Финляндын Улаан загалмай	Улаанбаатар хотод тохиолдож болзошгүй гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах чадавхыг сайжруулах
6	Төслийн нэр: МУЗН-ийн гамшгийн хариу арга хэмжээ авах хүчин чадлыг сайжруулах, малчдын гамшгийн эрсдэлийг даван туулах чадавхыг нэмэгдүүлэх: төсөл Хэрэгжүүлэгч:МУЗН Төсөл хэрэгжсэн байршил: МУЗН-ийн Ерөнхий нарийн бичгийн даргын газар, Булган, Өвөрхангай, Дундговь аймаг	Хугацаа: 2 жил /2016-2018/ Хандивлагч: Британы улаан загалмай	МУЗН-ийн гамшгийн хариу арга хэмжээ авах хүчин чадлыг үндэсний болон бүсийн түвшинд сайжруулах, малчдын бэлэн байдлыг ханган гамшгийг даван туулах чадавхыг бэхжүүлэх Төслийн хүрээнд 3 аймгийн малчдын бүлгүүд, гамшгийн сургалт сурталчилгаа, мэдээллийн 7 бүсийн төв хамрагдана
7	Төслийн нэр: “Олон нийтийн гамшгийн эрсдэлийн менежмент” төсөл Хэрэгжүүлэгч: ОБЕГ Төсөл хэрэгжсэн байршил: Төв, Өвөрхангай аймаг, Баянгол дүүрэг	Хандивлагч: Азийн гамшгийн бэлэн байдлын төв	-Гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах замаар олон нийтийн даван туулах чадавхыг нэмэгдүүлэх, -төсөл хэрэгжиж буй олон нийтийн дунд эмзэг байдал, хүчин чадлын үнэлгээ хийж, олон нийтээс гарсан саналын дагуу олон нийтийн оролцоотой гал унтраах баг байгуулах, -үерийн даланг сэргээн

			засварлах, усан сан байгуулах -гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах
8	"Хөдөө орон нутгийн малчид болон хот суурин газрын гамшгийн даван туулах чадавхыг бэхжүүлэх" Хэрэгжүүлэгч: МУЗН Төсөл хэрэгжсэн байршил: 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүрэг	Хугацаа: 4 жил /2016-2019/ Хандивлагч: Австралийн улаан загалмай нийгэмлэг	Орон нутгийн Улаан Загалмай дунд шатны хороонд Гамшигтай тэмцэх баг байгуулах, бүрэлдэхүүнийг сургах Орон нутгийн Улаан Загалмай дунд шатны хорооны орон нутгийн Онцгой байдлын байгууллагатай орон нутгийн удирдлагатай уялдаа холбоог сайжруулах - Малчдын бүлгийн эмзэг бүлгийн малчин өрхийн өвөлжөөний нөхцлийг сайжруулахад нь дэмжлэг үзүүлэх, амьжиргааны чадавхыг нэмэгдүүлэх - Суманд Гал унтраах баг байгуулах, тус багийг шаардлагатай багаж хэрэгслээр хангах, багийн гишүүдийг сургах

Эх сурвалж: ОБЕГ, 2018


Эдгээр төслүүдийн хурээнд олон нийтийн гамшгийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, тэдний оролцоотой гамшгийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ хийх болон олон нийтийн оролцоонд тулгуурласан сайн дурын баг байгуулах аргахэмжээг гол төлөв хэрэгжүүлж байна.

Өмнөх туршлагаас харахад төслийн хурээнд хийгдсэн ажиллагаанууд олон нийтэд энэ чиглэлээр үйл ажиллагаагаа тогтвортой авч явуулахад шаардлагатай мэдлэг, мэдээлэл, хөрөнгө, нөөц, идэвхжүүлэлт дутагдалтай байгаатай холбоотойгоор орон нутагт төсөл хэрэгжиж дууссан тохиолдолд зогсонги байдалд орж байна.

Увс аймгийн Малчин сум дахь олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт

Олон нийтэд түшиглэсэн гамшгийн эрсдэлийн менежментийн үйл явц нь олон нийтийн аюулд өртөх байдлын үнэлгээ, эмзэг байдалд дүн шинжилгээ хийжэнэ дагуу гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа явуулахад чиглэсэн төсөл, хөтөлбөрийн үндэслэлийг бий болгоно. Энэ утгаараа олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа эмзэг байдал, чадавхын үнэлгээг хийхээс эхэлдэг байна. Эмзэг байдал, чадавхын үнэлгээ нь иргэдийг гамшигт эмзэг болгож байгаа үндсэн шалтгаан, мөн тэдгээрийн гамшгийн эрсдэлийг болон гамшгаас учрах сөрөг үр дагаврыг бууруулах чадавхыг тогтоох, дүн шинжилгээ хийх үйл явц юм.

Дэлхийн зөн Монгол ОУ-ын байгууллагаас “Баруун аймгуудын гамшгийн эрсдэлийг бууруулах төсөл”-ийн хүрээнд олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хүрээнд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал(...-р зураг)-ыг боловсруулан Баян-Өлгий (Булган сум), Увс (Малчин сум), Ховд (Чандмань) гэсэн 3 суманд олон нийтийг оролцуулан гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийсэн.



Зураг ... Олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал'

Малчин сумын гамшгийн эрсдэлийн үнэлгээнд нийт 32 иргэн оролцсон ба оролцогчид сумын нутаг дэвсгэрт тохиолдох магадлалтай гамшгийн

эрсдэлийг зуд, цасан болон шороон шуурга, үер, газар хөдлөлт гэж тодорхойлж, эдгээрийн эрсдэлийг зуд, үерийн гамшгийн эрсдэл нь "Дунд" түвшинд, хүчтэй салхи, газар хөдлөлтийн гамшгийн эрсдэл нь "Их" түвшинд гэж үнэлсэн. Увс аймгийн Малчин суманд гамшгийн эрсдэлийн үнэлгээг олон нийтийн оролцоотойгоор үнэлсэн үнэлгээний тайланд тухайн сумын түвшинд тохиолдож болзошгүй гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг дараах байдлаар тодорхойлсон зөвлөмжийг гаргасан байна.

8-р хүснэгт. Увс аймгийн Малчин сумын нутаг дэвсгэрт тохиолдож

болзошгүй гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа'

Аюул		Үйл ажиллагаа	
Зэрэг	Нэр	Эмзэг байдлыг бууруулах чиглэлд	Чадавхыг нэмэгдүүлэх чиглэлд
1	Газар хөдлөлт	- Иргэдийн үл хөдлөх эд хөрөнгийг даатгалд хамруулах - Цахилгаан, дулаан хангамжийн хэвийн үйл ажиллагааг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх мөн эдгээрийн нэмэлт эх үүсвэрийг төлөвлөх - Сургууль, цэцэрлэг, хүн эмнэлэг зэрэг олон нийтийн барилга, байгууламжид эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэж аюулгүй байдлыг хангах арга хэмжээ хэрэгжүүлэх - Хүн амыг газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, аюулгүй байдлаа хангах арга ухаанд сургах	- Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах /урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох/ арга хэмжээг тусгах - Хүүхдэд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах мэдлэг, чадвар, дадал олгох - Иргэд, сайн дурынханыг газар хөдлөлтийн үед ажиллах арга ажиллагаанд сургах - Газар хөдлөлтийн гамшгийн үед хүн амыг нүүлгэн шилжүүлэх, түр орогнох байрыг төлөвлөж, дадлага сургууль хийх - Хөрөнгө гаргаж гамшгийн үеийн хэрэгцээтэй нөөцийг бүрдүүлэх
2	Цасан болон	- Хүчтэй салхи, шуурганы аюулаас урьдчилан	- Хүчтэй салхи, шуурганы эрсдэлийг бууруулах арга

'Увс аймгийн Малчин сумын гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайлан, 2014

	шороон шуурга	сэргийлэх, хохиролгүй /хамгийн бага хохирол амсаж/ даван туулах арга ажиллагаанд малчид, иргэдийг сургаж дадлагажуулах - Газар тариалан эрхлэгчдийг даатгалын үйлчилгээнд хамруулах - Барилгын дээврийг бэхэлж хүчитгэх, дорвитой хөрөнгө төсөвлөж дээврийг их засварт оруулах	хэмжээг сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө хувиарлах - Хүчтэй салхи, шуурганы аюулын талаар малчид, иргэдэд зарлан мэдээлэл түгээх систем бүрдүүлэх, тогтмол дадлага сургууль хийх - Сургуулийн сурагчдад хүчтэй салхи шуурганы үед аюулгүй байдлаа хангах арга ухаанд сургах - Шаардлагатай үед хүчтэй салхи, шуурганы аюулын үед ашиглагдах техник хэрэгсэл, түлш шатахуун, хоол, хүнсний нөөц, хангалтыг бүрдүүлэх
3	Их цас, зуд	- Малчин өрхийн амьжиргааны эх үүсвэрийг төрөлжүүлэх, малын үүлдэр угсааг сайжруулах, эрчимжсэн мал аж ахуйг дэмжих - Бэлчээр ашиглалтыг оновчтой төлөвлөх, ашиглах, худаг уст цэгийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх - Зам давааны хэвийн үйл ажиллагааг хангахад ашиглагдах техник хэрэгсэлтэй болох - Орон нутгийн удирдлагын зудын эрсдэлийг бууруулах ажиллагаанд хандах хандлагыг нэмэгдүүлэх	- Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, шаардлагатай хөрөнгө хувиарлах - Мал аж ахуйн салбарын гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг сумын хөгжлийн төлөвлөлтөд тусгах - Малчдад зудын эрсдэлийг бууруулахад чиглэсэн сургалт, сурталчилгааг тогтмол явуулах - Залуу малчдыг мал маллах уламжлалт арга ухаанд сургах
4	Үер	- Газар тариалан эрхлэгчдийг даатгалын үйлчилгээнд	- Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд үерийн

	хамруулах - Тариалсан талбайг үерт өртөхөөс хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлэх - Зам, гүүрийн ашиглалтын хэвийн ажиллагааг хангах - Хүн амд үер, аянга, цахилгаанаас өөрийгөө хамгаалах арга ухаанд сургах	эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгах - Сумын хөгжлийн төлөвлөлтөд үерийн эрсдэлийг бууруулах асуудлыг тусгах - Хүн амд үерийн эрсдэлийг бууруулах арга ухаанд сургах
--	--	--

Олон нийтийн оролцоотой хийсэн гамшгийн эрсдэлийн үнэлгээнээс гарсан дээрх зөвлөлжийг сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө байдлаар тусгаж хэрэгжүүлэх шаардлагатай. Малчин сумаас ирүүлсэн 2016, 2017 оны тайланд шинжилгээ хийж үзэхэд энэхүү үнэлгээнээс гарсан зөвлөмжийн дагуу ямар нэг ажил авч хэрэгжүүлээгүй байна.

Олон нийт болгамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөлт, төлөвлөгөөний хэрэгжилтийн бүхий л үйл явцад оролцож байх ёстой. Ингэснээр уг үйл явцаар дамжуулан олон нийтийн бодит хэрэгцээ, нөөцийг харгалзан үзэж, тухайн нөхцөлд тохирсон арга хэмжээ авч асуудлыг шийдэх магадлал өндөр болдог.

Малчин суманд хийсэн олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийн үнэлгээнд оролцсон иргэд үнэлгээнээс гарсан үр дүнд, зөвлөмжийн дагуу хийсэн арга хэмжээнд огт оролцоогүй байдалтай байна. Энэ нь манай улсад гамшгийн эрсдэлийн үнэлгээголон нийтийн оролцоотой хийж тухайн орон нутагт ямар аюулт үзэгдэл ихэвчлэн тохиолддог, үүний улмаас хэр хэмжээний гарз хохирол, эрсдэл учирч байсан, үүний шалтгаан нь юу вэ, хэн өртөөд байна вэ гэдэг асуудлуудыг тодорхойлж байгаа боловч эрсдэлийг бууруулах төлөвлөлт болон хэрэгжилт олон нийтийн оролцоогүйгээр явагдаж байгааг харуулна.

Олон нийтийн оролцоо бодитой байх нь олон хүчин зүйлээс хамаарна. Эдгээрээс хамгийн чухал нь оролцооны үр дүнд юу болсныг олон нийтэд мэдээлэх эргэх холбоо чухал байдаг байна. Оролцооны үр дүнд ямар санал гарсан, бодлого, шийдвэртээ ямар саналыг нь тусгасан, юуг ямар учир шалтгааны улмаас тусгаагүй талаараа нийтэд нээлттэй мэдээлэх нь оролцоог илүү үнэ цэнэтэй болгох, иргэн олон нийтийн идэвхийг нь илүү дэмжихэд тустай.

ДҮГНЭЛТ

Манай оронд тохиолдож буй байгалийн аюулт үзэгдэл, ослын давтамж, түүний улс орны эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь дэлхий дахиныг хамарсан уур амьсгалын өөрчлөлт, эдийн засгийн хөгжилтэй холбоотойгоор улам бүр нэмэгдэх хандлагатай байна.

Монгол Улс шиг хөгжиж буй орны хувьд иргэдийн амьжиргааны түвшин доогуур, нөөц багатай, дэд бүтэц сул хөгжсөн. нийгмийн үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал газарт хүн ам таруу суурылсан, гамшгаас өөрийгөө болон ойр дотны хүмүүсээ авран хамгаалах мэдлэг, дадал дутмаг байдаг зэргээс шалтгаалж гамшигт иргэд хамгийн ихээр өртөж, гамшгийн улмаас учирч буй хохирлын хэмжээ жилээс жилд нэмэгдэж байна.

Олон нийтэд түшиглэсэн гамшгийн эрсдлийн менежмент нь олон нийтийг сонгох, харилцан ойлголцлыг бэхжүүлэх, ойлголцох, гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх, гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөлт хийх, гамшгийн эрсдэлийн удирдлагын олон нийтийн байгууллагабайгуулж, сургалт явуулах, олон нийтийн оролцоотойгоор хэрэгжүүлэх, оролцоот хяналт-шинжилгээ ба үнэлгээ гэсэн дараалсан долоон үе шатаар хэрэгждэг цогц үйл явц ажээ.

Дэлхий дахинд гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хамгийн сайн, тэргүүн туршлагыг тодорхойлж буй Япон улс гамшгаас урьдчилан сэргийлэх олон нийтийн байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг судалж үзэхэд дараах туршлагыг авч болохоор байна. Үүнд:

Иргэд сайн дураараа нэгдэж байгуулагддаг

Гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах талаар олон нийтийн байгууллагаас хийх үйл ажиллагааг тодорхойлж өгсөн

Гамшгаас урьдчилан сэргийлэх олон нийтийн байгууллагаас явуулах гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны зардалд орон нутгийн засаг захиргаанаас дэмжлэг үзүүлдэг

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг бүх талын түншлэлд суурилж явуулдаг.

Монгол Улсад Олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийг бууруулах үзэл санааг хэрэгжүүлэх эрхзүйн орчин сайжирсан байна. Тухайлбал, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрхзүйн орчныг тодорхойлсон тулгуур хуулинд болох Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгад иргэд, олон нийтийн оролцоог хангах зохицуулалтыг тусгасан зүйл, заалтын тоо болон зохицуулалтын цар хүрээ нэмэгдсэн байна.

Дэлхийн олон оронд тухайн улс үндэснийхээ онцлогийг тусган амжилттай хөгжиж буй гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үйл ажиллагаа манай улсад ихэвчлэн олон улсын байгууллагын санхүүжилттэй төслийн хүрээнд орон нутагт хэрэгжиж иржээ. Харин 2015 онд “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотойбууруулах үндэсний хөтөлбөр” баталсан

улмаар Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгуудыг тус тус баталсанаар энэ үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалтыг сайжруулахад бодитой хувь нэмэр оруулж байна.

Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэхийн тулд Онцгой байдлын байгууллагын төдийгүй нутгийн захиргааны байгууллагын хүрээнд удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах асуудлыг авч үзэх шаардлагатай. Монгол Улсад гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалтыг сайжруулахын тулд нэгд, гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагаагаар дамжуулж олон нийтийг идэвхжүүлэх, хоёрт, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд олон нийтийн оролцооны чиглэлийг тодорхой болгох, гуравт, гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үйл ажиллагааны санхүүжилтыг боловсронгуй болгох чиглэлд анхаарч ажиллах шаардлагатай.

Д.Золжаргал-Лууль *сахихулахын удирдлагын академийн
8062-р дамжааны суралцагч, магистр, хошууч*

ҮЕРИЙН АЮУЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРИМ АСУУДАЛ

Хураангуй: Өнөөдрийн байдлаар гамшигийн төрлүүдээс хамгийн ихээр хор хөнөөл учруулж байгаа гамшиг нь байгалийн гаралтай буюу үерийн гамшиг өндөр хэмжээнд анхаарал татах болсон учраас энэхүү сэдвийг судлан танилцуулахыг зорилоо.

Түлхүүр үг: Үерийн аюул, гамшиг, байгалийн аюулт үзэгдэл, хүний хүчин зүйлээс хамааралтай осол аварь, үргэлжилсэн зүс бороо, богино хугацаанд орох аадар бороо, их цасны улмаас үүсэх шар усны үер.

Оршил.

Дэлхий дээр тохиолдох гамшиг, байгалийн аюулт үзэгдэл болон хүний хүчин зүйлээс хамааралтай осол аварь, бүс нутаг хоорондын мөргөлдөөн, террорист халдлагын тоо жилээс жилд нэмэгдэж түүнээс учрах хор уршгийн үр дагавар улам бүр нэмэгдэж байгаа нь эдгээр аюулаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалах асуудал хурцаар тавигдаж байгаа бөгөөд улс орон бүр өөр, өөрийн эдийн засаг, нийгэм, байгаль цаг уур, хууль эрх зүйн орчинтойгоо уялдуулан төрөл бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Манай орны хөрс, ургамал, геологи, уур амьсгалын өндрийн бүс бүслүүр, олон жилийн цэвдэг ул хөрсний тархацтай уялдан нийт нутгийн уруйн үер үүсэх нөхцөл, учруулж болох аюулын түвшнээр *их хүчтэй, хүчтэй, дунд, сул, маш сул хүчтэй* гэж тав хуваадаг байна.